# МОНГОЛ УЛС
# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр Дугаар А/347 Мандалговь

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.5, 7.1.6 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн иргэн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын хагалгааны сувилагчаар ажиллаж байсан Дамбын Бямбасүрэн нь хүнд өвчний улмаас Солонгос улсад эмчилгээ хийлгэх шаардлага үүссэн нөхцөл байдал, аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдлийг харгалзан үзэж нэг удаагийн мөнгөн тусламжийг үзүүлсүгэй.

2. Тусламжид шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4822111159